



Г УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Р.ХАЙДАВ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2012.06.03 № 126 ВДХ-СМ/2013/СТА-ЗГСБ

Г ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ Г

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК “Эрчим хүчний хэмнэлтийн төсөл”-ийн хүрээнд Сангийн яамтай 1997 онд дамжуулан зээлийн гэрээ байгуулж, гэрээний хавсралтын дагуу төлбөрийг төлж ирсэн байна. Энэхүү төслийн үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус 200 гаруй байгууллагуудад хэрэгжиж байгаа тул Төрийн өмчийн хорооны 2010 оны 436, 2011 оны 61 дүгээр тогтоолоор нийт 12,041,195,889.10 төгрөгийн төслөөр бэлтгэгдсэн үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэн бүртгэж, хөрөнгийн үнийг төлөх талаар дамжуулан зээлийн гэрээг эдгээр байгууллагуудтай “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК байгуулсан байна.

Аудитын явцад тус компаний дамжуулан зээлийн төлөлтийг 2012 оны байдлаар тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2012 онд тус компани дамжуулан зээлд 1.8 тэрбум төгрөгийг илүү төлөлт хийсэн боловч зээлийн үндсэн төлбөрийг багасгах гэрээг шинэчлэн байгуулаагүй,
- Аж ахуйн нэгж байгууллагуудтай дамжуулан зээлийн гэрээ, төлбөрийн талаар 2012 оны эцэст дүгнэж акт үйлдээгүй,
- Нийт дамжуулан зээл авсан байгууллага бүрээр зээлийн төлөлтийн талаар дэлгэрэнгүй, тодорхой тайлан гаргаагүй,
- Зээлээ төлөхгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн талаар нэгдсэн судалгаа гаргаагүй,
- Дамжуулан зээлийн талаар СЯ-наас зөвшөөрөл аваагүй, СЯ-д тайлан судалгааг гаргаж өгөөгүй байна.
- Засгийн газрын тогтоолоор 2012 онд бүтцийн өөрчлөлтөд орж татан буугдсан, нэр өөрчлөгдсөн гэх мэт төсөвт байгууллагуудын гэрээг шинэчлэн хийгээгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;”, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 7.2-д “Зээлдэгч дамжуулан зээлдүүлсэн зээлийн ашиглалтын явцын талаархи тайлан, танилцуулгыг хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн шугамаар нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын нийлүүлэлт,

үлдэгдлийн мэдээ, тайланг тухай бүр Сангийн яаманд ирүүлнэ.”, 8.6-д “Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн хүрээнд Сангийн яамны зөвшөөрлөөр гуравдагч этгээдтэй давхар гэрээг байгуулж болно. “гэсэн заалтуудыг зөрчсөн, хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээрх зөрчлийг арилгаж, дамжуулан зээлийн тайлан, судалгаа, гүйцэтгэлийг гарган 2013 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ий Эдийн засаг, санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч П.Оюунчимэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Л.ОДГЭРЭЛ